Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АНХАН БОЛОН ЛАВЛАГАА ШАТЛАЛЫН ТУСЛАМЖИЙН ХЭЛТСИЙН СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Ц.ХАНДАРМААГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Сувилахуйн, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг шинэчлэн батлуулна. | Батлагдсан журам | ЭМС-ын 2015 оны “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай” 329 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт | Журмыг батлуулсан байна. | Журмын төслийг боловсруулж, 2 удаа хэлэлцүүлж, албан бичгээр ЭМБ-аас санал авч тусган, төслийг удирдлагуудаар тойруулж санал авч байсан ч удирдлагын баг шинэчлэгдсэн холбоотой дахин санал авч байна. | 01-06 сар | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.2. “Сувилахуйн албаны дүрэм, чиг үүрэг батлах тухай” 495 дугаар тушаалыг шинэчилж батлуулна. | Батлагдсан дүрэм, чиг үүрэг | ЭМС-ын 2015 оны “Сувилахуйн албаны дүрэм, чиг үүрэг батлах тухай” А/495 | Эхний төслийг боловсруулсан байна | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/424 дүгээр тушаалаар батлуулсан. Тус тушаалыг Эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт 5/4434 тоот албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | дүгээр тушаал | | | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Сувилахуйн тусламж, үйлчилгээний арга хэмжээний төлөвлөгөө (2023-2024) -г хэрэгжүүлэх | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь 100 | 80% | Хэрэгжилтийн хувь 90 | 100 хувь -15, 90 хувь -1, 20 хувь -1, Нийт 94,7 хувь байна. Тайлангаас,<br><br>- Тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор олгодог мөнгөн тэтгэмжид туслах сувилагчийг хамруулах эрхзүйн орчин бүрдүүлэх талаар судлаж байна.<br><br>- 2023 оноос БШУЯ-тай хамтран, сувилагч мэргэжлээр орон нутгийн захиалга, эрэлтийг харгалзсан бодлого хэрэгжүүлж эхэлсэн. 2023 онд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулиас Өвөрхангай аймгийн БОЭТ-ийг түшиглэн сувилагчийн 3 жилийн дипломын сургалтдаа 46 оюутан элсүүлэн сургаж байна. Элсэгчид 100% Өвөрхангай аймгаас буюу сум бүрээс 1-2 оюутан суралцаж байна. Танхимийн сургалтыг аймгийн Политехникийн коллежийг түшиглэн, дадлага сургалтыг БОЭТ-д байрлан хичээллэж, багш нар АШУҮИС-ийн Сувилахуйн төв сургуулиас очиж томилогдон сургалтын чанар, үр дүнд анхааран ажиллаж байна.<br><br>- Орон сууцаар хангах чиглэлээр: Орон сууцны урьдчилгаа/нэг удаагийн мөнгөн тэтгэмж буюу 1,019,0 сая гаруй төгрөгийг 347 ажилтанд, түрээслээд өмчлөх эрхийг 16 ажилтанд олгон, орон сууцны ипотекийн зээлд 191 ажилтанг хамруулжээ.<br><br>- Эрүүл мэндийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/424 дүгээр тушаалаар Сувилахуйн албаны үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн батлуулсан.<br><br>- Эрүүл мэндийн сайдын 2024 оны 286 дугаар тушаалаар Эх баригчийн ажлын байрны | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | тодорхойлолтыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна.<br><br>- 2024 оны тайлангаар, 178 төрлийн 1172 ширхэг багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг 1817,8 сая төгрөгний санхүүжилтээр авч, хангажээ. 11 байгууллага сувилагчийн ачааллыг хөнгөвчлөх технологи нэвтрүүлэн ажиллажээ.<br><br>200 гаруй эх баригч, сувилагч нарыг БНСУ, БНХАУ-д богино хугацааны сургалад хамруулсан.<br><br>- 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Сувилагч танаараа бахархъя -2024” арга хэмжээний “Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгаа” салбар хуралдаанаар “Сувилахуйн хүний нөөц, нийгмийн баталгааны талаар”, “Сувилагчдын нийгмийн баталгаа, ажлын ачаалал”, “Нийслэлийн харъяа эрүүл мэндийн байгууллагын сувилахуйн хүний нөөц”, “Сувилахуйн хүний нөөцийн чиг хандлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, зөвлөмж гаргасан.<br><br>- Шинэ сувилагч, шинэ эх баригчийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг батлан, Орхон аймгийн БОЭТ, УХТЭ дээр хэрэгжүүлж эхлээд байна.<br><br>“Ерөнхий сувилахуйн түгээмэл үйлдлийн стандарт”-ын 50 төслийг Стандарт, хэмжил зүйн газарт 2024 оны 4 сард 2/1581 тоот албан бичгээр хүргүүлж, саналыг тусган ажиллаж байна. “Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар”-ыг Эрүүл мэндийн сайдын 2024 оын А/22 дугаартай тушаалаар батлуулсан. | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4. | Арга хэмжээ 1.4. Сувилагчийн ачаалал үнэлэх жишиг аргачлал боловсруулж турших | Туршсан тайлан | - | Сувилагчийн ачааллыг 3 аймагт үнэлсэн байна. | "Багш-шавийн эрдмийн уулзалтын хүрээнд сувилахуйн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох ажлын удирдамж"-ийг газрын даргаар батлуулан Аймаг, нийслэлийн ЭМГ-т 2024 оны 3 сарын 11-ний өдрийн 5/1006 тоот албан бичгийг хүргүүлж, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран хэрэгжүүлж байна. Тус удирдамжийн нэг зорилт нь Тус удирдамжийн нэг зорилт нь Сувилагчийн ажлын байранд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, нотолгоотой шийдвэр гаргахад ашиглана гэсэн. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн ЭМБ-ын сувилагч нарын ажлын байрны тулгамдсан асуудлыг тодорхойлохдоо ОУ-д сувилагчийн ажлын ачааллыг Nursing activities score /NAS/- Сувилахуйн тусламжийн үйл ажиллагааны оноогоор тооцон гаргадаг аргачлалыг ашигласан. NAS нь эмчилгээ, сувилахуйн тусламжийн 23 зүйлийн агуулгаас бүрдэнэ. Нэг эмчлүүлэгчийг 177 оноонд хүртэл үнэлэх боломжтой. Нэг тасагт байгаа нийт эмчлүүлэгчийн тус бүрийн NAS онооны нийлбэрийн 100 оноо тутамд 1 сувилагчийн хэрэгцээтэй ба 1 оноо тутамд 14.4 минут зарцуулах ёстой гэж үздэг байна. Үнэлгээний дүнгээс, Ажлын ачаалал маш их 32,2%, их 43,9%, дунд 22,6% буюу 76.1 хувь нь ачаалалтай гэсэн урьдчилсан дүгнэлт байна. Ажлын цагийн зарцуулалтыг задлан харвал, баримт бичиг хөтлөх-72,6%, эмчилгээ хийх -14%, сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэх 6,9%, үүрэг даалгавар -2,6%, бусад 4% гэж гарчээ. Мөн Та ажлын цаг дууссанаас хойш ажлаа дуусгахын тулд үргэлжлүүлэн ажилладаг уу гэсэн асуултад ихэвчлэн | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | байнга гэж 54,5% нь хариулжээ. Урьдчилсан санал, дүгнэлт: Сувилагчийн ажлын цагт хийгдэх ажлыг хүн болон гүйцэтгэх ажилбараар тогтоох, E-health программ, хэрэглээний компьютер сайжруулах.<br><br>2024 оны 11 сард Сувилагчийн ажлын байранд тулгамдаж буй асуудлыг тодорхойлохоор Орхон аймгийн БОЭТ-ийн Хүүхдийн тасаг, Завхан аймгийн НЭ-ийн Мэс засал, Төв аймгийн НЭ-ийн Дотрын тасгийн нийт 36 сувилагч ажлын ачааллаа Nursing activities score /NAS/- Сувилахуйн тусламжийн үйл ажиллагааны оноо буюу аргачлалыг ашиглаж өөрсдөө үнэлсэн. Тус үнэлгээний дүнгээс харахад, ачаалал их, илүү цагаар ажиллаж байгаа хэдий ч сувилагчдын ажилдаа болон үйлчлүүлэгчид хандах хандлага, сэтгэл зүйн байдал эерэг гарсан. | | |
| 5 | Арга хэмжээ 1.5. Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний зааврыг батлуулна. | Батлагдсан заавар | - | Зааврыг батлуулж, танилцуулах уулзалт зохион байгуулна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/22 дугаар тушаалаар батлуулж, 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 5/234 тоот албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн ӨЭМТ, Хавдар судлалын үндэсний төв, Дорнод, Хэнтий, Төв аймаг, БГД-ийн эмч мэргэжилтэнд танилцуулах уулзалтыг хийж, мэргэжил арга зүйгээр хангасан. Мөн ХНХЯ-ны АХБ-ны ажлын хэсгийн хурал, Ахмад настны тухай хуулийн шинэчилсэн найруулгын уулзалтад танилцуулсан. | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6 | Арга хэмжээ 1.6. Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэнэ | Үйл ажиллагааны тайлан | - | Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн “Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэх тухай” А/204 дугаар тушаалыг батлуулсан. Мөн зохион байгуулах нарийвчилсан төлөвлөгөөг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Сувилагч танаараа бахархъя -2024” арга хэмжээг зохион байгуулж, нийт 2500 төлөөлөгч оролцлоо. Мөн энэ удаагийн Олон улсын сувилагчдын өдрийн нэг онцлог нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан Сувилахуй, эх барихуйн стратегийн 4 зорилт буюу “Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын шинэчлэл”, “Сувилахуйн хүний нөөцийн хөгжил”, “Сувилахуйн удирдлага, манлайллын шинэчлэл”, “Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тусламж, үйлчилгээний шинэчлэл”, сэдэвт 4 салбар хуралдааныг зохион байгуулж, сувилахуйн салбарт гарсан ололт амжилт, хөгжил дэвшил, шинэчлэл, сувилахуйн тусламж, үйлчилгээг шинэ шатанд гаргах цаашдын бодлого, чиглэлээ хэлэлцэн, нэгдсэн зөвлөмж гаргалаа. | 01-06 сар | 100 |
| **Зорилт 2. “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих” чиглэлээр** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх зааврыг шинэчлэн батлуулна. | Сайдун тушаал | ЭМС-ын 2015 оны “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам батлах тухай” 329 | Зааврыг батлуулсан байна. | Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар (146 хуудас)-ын төслийг боловсруулж, Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авч, газар хэлтсийн даргаар санал авахад бэлэн болсон. | 06-12 сар | 80 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | дүгээр тушаалын 2 дугаар хавсралт | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний (2024-2027) төлөвлөгөөг батлуулна./117/ | Батлагдсан төлөвлөгөө | - | Төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна. | Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний (2024-2027) төлөвлөгөөний төслийг 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг төлөвлөн боловсруулсан. Тус төслийг хэлэлцүүлэх уулзалтыг 10 сарын 29-ний өдөр зохион байгуулж, хэлэлцүүлсэн. Тус хэлэлцүүлгийн үеэр ДЭМБ-аас гаргасан 2023 он хүртэлх эрүүл нажмилтын төлөвлөгөөтэй уялдуулан дахин боловсруулах, энэ үеэр ДЭМБ-аас зөвлөх 12 сарын 16-20-ны хооронд ирж мэргэжил арга зүйгээр хангах тул тус төлөвлөгөөний төслийг хойшлуулсан. | 01-06 сар | 70 |
| 3. | Арга хэмжээ 2.3. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний сувилахуйн чиглэлээр тусгасан арга хэмжээг /2024-2027/ хэрэгжүүлнэ./132/ | Хамтран ажилласан үйл ажиллагааны тайлан | - | Нийт арга хэмжээний 20 хувийг хэрэгжүүлнэ. | Тус төлөвлөгөөний 4.10. Эмзэг бүлгийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйл төлөвлшүүлэх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд: Тэргэнцэртэй болон байнгын хэвтэрт байдаг иргэд, тэдний гэр бүл, асран хамгаалагч нарын эрүүл мэндийн боловсрол дутуугаас болж холголт цооролт их үүсдэг, тусламж, үйлчилгээг хүндэрсэн хойно нь авдаг, мөн холголт, цооролтыг үнэлэх, асаргаа, сувилагаа үзүүлэх мэдлэг хангалтгүйгээс хүндрүүлэх асуудал их гарч байна. Иймээс Мэс заслын мэргэшсэн сувилахуйн нийгэмлэгтэй хамтран Эрүүл мэндийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр "Гэрээр байнгын асаргаанд байгаа иргэдийн асран хамгаалагчид, сувилахуйн тусламж үзүүлж байгаа өрхийн сувилагч нарыг чадавхжуулах" төслийг хэрэгжүүлж, ЧД-ийн 16 ӨЭМТ-ийн сувилагч, 19 хорооны 50 орчим тэргэнцэртэй иргэд, хэвтрийн үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, асран хамгаалагч нарт зориулан, холголт, цооролтын үеийн асаргаа, | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | сувилгааны талаар эрүүл мэндийн боловсрол олгохоос гадна гарын авлага материалаар хангасан. | | |
| 4 | Арга хэмжээ 2.4. Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна./149/ | Өгсөн саналын тоо | | Санал өгсөн | Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн тэргүүлэх чиглэлд Сувилахуйн бие даасан тусламж, үйлчилгээ эрхлэх Сувилахуйн төвийг хөгжүүлэх талаар санал өгсөн. Мөн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг хуулийн ажлын хэсэгт өгсөн. | 01-12 сар | 100 |
| 5 | Арга хэмжээ 2.5. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. /150/ | Өгсөн саналын тоо | | Санал өгсөн | Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуурт дараах эрхзүйн барит бичгийг ашиглах талаар санал өгөв. Үүнд.<br>✓ Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/381 дүгээр тушаал. "Сувилахуйн төвийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм, Сувилахуйн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт, Сувилахуйн төвд илгээх үйлчүүлэгчийн өвчин эмгэгийн жагсаалт",<br>✓ Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/182 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 1.1.Гэрийн сувилгааны иж бүрдлийн цүнх болон бусад хэрэглэгдэх зүйлс, хөтлөх бичиг баримтын жагсаалт,<br>✓ Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/475 дугаар тушаалаар "Улсын хэмжээнд 2022-2025 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаар", | 01-12 | 100 |

15

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | ✓ MNS6755:2019 Сувилахуйн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт | | |
| **Зорилт 3. "Сувилахуйн төв, хөнгөвчлөх асаргаа, сувилгааны төвийн тусламж, үйлчилгээг нэгдсэн зохицуулалт, мэргэжил арга зүйгээр хангах" чиглэлээр** | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 3.1. Хөнгөвчлөхийн үеийн сувилахуйн богино хугацааны багц цагийн сургалтыг зохион байгуулах арга хэмжээ авна. | Сургалтын сэдэв, хамрагдсан сувилагчийн тоо | 25 | 50 | Сувилахуйн болон хөнгөвчлөхийн нийгэмлэг холбоо, ЭМХТ-д "Гэрээр үзүүлэх хөнгөвчлөх эмчилгээний үеийн асаргаа сувилгаа", "Хэвтрийн хүмүүст үзүүлэх асаргаа, сувилгаа" сэдэвт сургалтын төлөвлөгөө гаргаж 2024 онд хамтран ажиллах тухай 2023 оны 12 дугаар сарын 14-ний 5/5709 тоот албан бичгийг хүргүүлж хамтран ажиллаж байна.<br>2024 оны 01 - 11 сард "Хөнгөвчлөх сувилахуй" сэдэвт богино хугацааны багц цагийн сургалтыг Монголын хөнгөвчлөх эмчилгээний нийгэмлэгтэй хамтран зохион байгуулж аймаг, нийслэлийн ӨЭМТ-ийн нийт 200 гаруй сувилагч нар оролцлоо.<br>Хөнгөвчлөхийн сувилахуй 3 сарын хугацаатай төрөлжсөн мэргэшил олгох сургалтад 2024 оны хаврын элсэлтээр нийт 11 хүн элсээд байна. | 01-06 сар | 100 |
| | Арга хэмжээ 3.2. Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Үйл ажиллагааны тайлан | - | 1 | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/283 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын тусламж, үйлчилгээний жагсаалтад хөнгөвлөх тусламж, үйлчилгээг гэрээр үзүүлэхээр тусгаж өгсөн. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 05 дугаар тогтоолд Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж, үйлчилгээний тохиолдолд суурилсан төлбөрийн хэмжээний 5 буюу гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээнд Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг 150,000₮-ийн төлбөрийн хэмжээтэйгээр үзүүлэхээр тусгасан.<br><br>Хөнгөвчлөх эмчилгээний нөхцөл байдалд хийсэн үнэлгээний НЭМГ-т өгсөн чиглэлийг үндэслэн Хавдрын | 01-06 сар | 100 |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний нөхцөл байдлын үнэлгээ хийх ажлын удирдамжийг НЭМГ-ын даргын 2024 оны 06 дугаар сарын 19-27-ны өдрийн А/88 дугаар тушаалын дагуу харьяа Баянгол, Чингэлтэй, Налайх, Багануур дүүргийн эрүүл мэндийн төв, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул нэгдсэн эмнэлэгт хийсэн. Үнэлгээгээр 2023 онд БЗД, Багануур дүүргийн хөнгөвчлөхийн бие даасан тасагтай байсан бол 2024 онд нэмээд, СХД НЭ бие даасан хөнгөвчлөхийн тасагтай болсон байна. 2023 онд Нийслэлийн хэмжээнд 3390 хүнд хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн бол 2024 онд 4702 буюу 1312 хүнээр илүү үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлсэн байна. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас жил бүрийн 10 дугаар сарын хоёр дах долоо хоногийг "Хөнгөвчлөхийн тусламж үйлчилгээ ба хосписийн Дэлхийн өдөр" хэмээн зарладаг тул энэ өдрийн хүрээнд Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хавдар судлалын Үндэсний төв, Монголын Хөнгөвчлөх Эмчилгээний Нийгэмлэгтэй хамтран нийслэлийн өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарын дунд "Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний шилдэг эмч" шалгаруулах 3 үе шаттай тэмцээнийг зохион байгуулж дүгнэсэн. Монголын Хөнгөвчлөх Эмчилгээний Нийгэмлэгтэй хамтран Нийслэлийн 149 өрх, тосгоны эрүүл мэндийн төвийн 152 эмч 178 сувилагч нарыг хөнгөвчлөхийн тусламж, үйлчилгээг үзүүлэх мэдлэг, чадварт сургасан. Хөнгөвчлөхийн сувилахуй номыг боловсруулж, 300 ш-ийг хэвлэн тараасан. Ингэснээр нийслэл дэх хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн.<br><br>Эрүүл мэндийн салбарын 2025 оны төсвийн төсөл, 2026, 2027 оны төсвийн төсөөлөл"-д 4 тэрбум төгрөгийн 19 төрлийн ТТ-ийн үндэслэл, хэрэгцээ шаардлагыг боловсруулж тусгасан. Ингэснээр Сувилахуй, | | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хөнгөвчлөхийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлэх, өвчин эмгэгийн эдгэрэлтийг түргэсгэн улмаар ор хоногийг бууруулах ач холбогдолтой. | | |
| | ЗГҮАХ 2.1.7.3 Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргахад хамтран ажиллах /65/ | Өгсөн саналын тоо | - | Санал өгсөн | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 3 санал өгсөн: 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр ХНХЯ-наас зохион байгуулсан “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн урт хугацааны тусламж, үйлчилгээний шинэлэг тогтолцоог хөгжүүлэх нь” төслийн Ахмад настанд үзүүлж буй Кейс менежментийн туршилтын үйлчилгээ танилцуулах уулзалт, ХНХЯ-ны Ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх төслийн хүрээнд Ахмад настанд үзүүлж буй Кейс менежментийн туршилтын үйлчилгээ танилцуулах уулзлатад оролцож, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан зааврыг хамтран хэрэгжүүлэх, Ахмад настны тухай хуульд “Кейс менежмент” -ийн тодорхойлолт оруулах талаар саналыг өгсөн. Ахмад настны тухай хуулийн шинэчлэн найруулах ажлын хэсэгт дээрх зааварт тусгагдсан “Эмзэг бүлгийн ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх кэйс менежмент” гэж асран хамгаалагчгүй, ганц бие, бие даах чадваргүй, ахмад настны олон хам шинжтэй, гэр бүлийн гишүүдийн зүгээс дарамт шахалт, хүчирхийлэл үзүүлдэг, санхүүгийн эрсдэлтэй ахмад настанд нийгмийн хамгааллын тусламж үзүүлэх” тодорхойлолтыг тусгаэ хэлэлцүүлж байна. Мөн 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн АХБ-ны Урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх төслийн уулзалтад оролцож, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.7-д заасан журам, жагсаалтыг батлах тал дээр хамтран ажиллах саналыг өгсөн. | 01-06 сар | 50 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ)1. 1 Монгол Улсын Хөдөлмөрийн баатруудын тусламж, үйлчилгээг зохицуулах | Авсан арга хэмжээний тайлан | - | | Газрын даргын өгсөн үүргийн дагуу "Монголын хөдөлмөрийн баатруудын холбоо" төрийн бус байгууллагын төлөөлөл Эрүүл мэндийн сайдтай 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр уулзаж 160 гаруй баатруудын эрүүл мэндийг хамгаалах асуудалд онцгойлон анхаарч хамтран ажиллах саналыг тавьсны дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна:<br>- Баатруудын тавьсан хүсэлтийн дагуу энэ оны 01 дүгээр сарын 09-ний өдөр холбогдох төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Нийслэлийн эрүүл мэндийн газрын удирдлагуудтай уулзаж, санал солилцож, хамтран ажиллах албан тушалатын мэдээллийг авсан.<br>- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5/131 тоот албан бичгээр УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт чиглэл хүргүүлж, баатруудын эрүүл мэндийн мэдээллийг хүлээн авч, хэвтэрт байгаа баатруудын мэдээллийг гарган, аймаг нийслэлд чиглэл өгч ажилласан.<br>- Эрүүл мэндийн яам Монголын хөдөлмөрийн баатруудын холбоо ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийн төслийг боловсруулж, 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Эрүүл мэндийн сайд Монголын хөдөлмөрийн баатруудын холбооны удирдах зөвлөлийн төлөөлөлтэй хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.<br>- УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, Геронтологийн үндэсний төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газраас хөдөлмөрийн баатруудын эрүүл мэндийн хариуцан ажиллах албан тушаалтны болон тус холбооны дээрх байгууллагуудтай хамтран ажиллах удирдах зөвлөлийн гишүүдийн жагсаалтыг гаргасан. Тус хамтран ажиллах албан тушаалтны нэр, албан тушаал, утасны дугаарыг 2024 оын 01 сарын 25-ны өдрийн 5/350 тоот албан бичгээр УНТЭ, УХТЭ, УГТЭ, ХСҮТ, ГССҮТ, Геронтологийн үндэсний төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт хүргүүлж, өнөөдрийг хүртэл удирдлага арга зүйгээр хангаж ажиллаж байна. | 01-06 сар | 100 |

155

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | - 2024 оны 03 сарын 26-ны өдөр Монголын хөдөлмөрийн баатруудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүд Эрүүл мэндийн сайдтай уулзаж, ном хэвлүүлэх, хүүхэд, залуучуудад эрүүл зан зүйл төлөвшүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэхэд Санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүссэний дагуу төслийг хамтран боловсруулж, тус яамны Нийтийн эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. Одоогийн байдлаар судалгаанд авсан төлөвтэй байна.<br><br>Тус холбооны удирдах зөвлөлийн дарга, гишүүдтэй байнга холбогдож асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. | | |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж, үйлчилгээ болон үндсэн тусламж, үйлчилгээний хэрэгжилт, зохицуулалт | Авсан арга хэмжээний тайлан | - | | Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу:<br><u>Алба бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн байдал</u><br>Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, хөдөлмөрийн чадвар алдалт, байнгын асаргаа сувилагаатай холбоотой нийт 300 (Сувилахуйтай холбоотойг хассан болно) гаруй албан бичгийг зохицуулж, шийдвэрлэж ажилласан: Явсан бичиг 59, ирсэн бичиг 200 гаруй, өргөдөл, гомдол 25, 18 иргэнтэй биечлэн уулзаж, асуудлыг судлан тухай бүр шийдвэрлэсэн.<br><u>Хууль эрхзүй бодлогын түвшинд:</u><br>ХНХЯ-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төсөл, хуулийн үзэл баримтлал, хуулийн танилцуулга, дагалдан гарах хуулийн төслүүдэд 85 дугаар дотоод меморандумаар газар, хэлтсүүдээс санал авсан. Саналыг боловсруулж, 4 заалт бүхий саналыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1а/1798 албан тоотоор хүргүүлсэн.<br>ХНХЯ-д "Мэргэжлийн өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн ажиллах дүрэм батлах тухай" хамтарсан тушаалын төсөлд Эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасанаар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд байхаар хуульчилсан. Иймээс тус мэргэжлийн өвчин судлалын төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн эрхзүйн зохицуулалтыг | | 100 |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | нягтлан үзэх саналыг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 2/1526 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар, Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт, Өлсгөлөн зарласан үедхэтлөх маягтын загвар батлах тухай" 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/61, А/40 дугаар тушаалыг батлуулан, 2024 оны 5/753 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт Засгийн газрын тогтоолоор батлагдах "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдгийг шалгаруулах журам"-ыг шинэчлэх төсөлд ЭМБ-уудаас 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 2/998 тоот албан бичгээр санал авч, /5 хуудас/ саналыг боловсруулан 03 сарын 27-ны өдөр 2/1258 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/10 дугаар тушаалаар байгуулагдсан "Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний заавръг боловсруулах ажлын хэсэг"-т ажиллаж байна. Тус заврын төсөлд 2024 оны 4 сарын 22-ны өдрийн 97 дугаар дотоод меморандумаар санал авч ажиллаж байна.<br><u>Хэрэгжилт, зохицуулалтын талаар:</u><br>- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийн хурлын хөтөлбөрийг боловсруулан, яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан. Хурлаар 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар хэлэлцэв. Тус төлөвлөгөөнд Хөгжлийн бэрхшээлийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх -13, Хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, олон нийтийн оролцоог идэвхижүүлэх -7, Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвийн | | |

197

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хариуцах 7 арга хэмжээг тусган ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах дэд зөвлөлийн 2024 оны эхний хагас жилийн тайланг ирүүлэх тухай 2/2375 тоот албан бичгийг Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт хүргүүлэн тайланг авч байна.<br>- 2024 оны 04 дүгээр сарын 6, 13, 20, 27-ны өдрүүдэд Эрүүл мэндийн яам Эх, хүүхдийн эрүүл мэндийн төв (ЭХЭМҮТ), "Эрхэм нандин сувд" ТББ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв хамтран хөдөө орон нутгийн 500 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах, хөгжлийн үнэлгээ хийх, эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдлэг, ойлголт олгох арга хэмжээ зохион байгуусан. Мөн эцэг эхийн хүсэлтээр Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төвд албан тоот хүргүүлж, тархины саа саажилт, аутизм, эпилепси, даун, усжилт, уйланхайтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулан нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношилгоог хийлээ.<br>- ДЭМБ-тай хамтран ICF-ыг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх төлөвлөгөө боловсруулах, сургалтыг үе шаттай зохион байгуулах, мөн үүнтэй холбоотойгоор WHO-DAS 2.0 программыг нэвтрүүлэхээр 2024 оны 3 сарын 26-ны 1а/65 тоот албан бичгээр хүсэлтийг хүргүүлж ажиллаж байна.<br>- 2024 оны 02 дугаар сарын 20-ны Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбоо "Эрхэм нандин сувд" ТББ-ын хүсэлтээр өдөр уулзаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх урт хугацааны тусламж, үйлчилгээг үзүүлэх, түүний санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх дэмжих төюийн үйл ажиллагаатай танилцахыг хүссэн. Хүсэлтийн дагуу 2024 оны 2 сарын 28-29-ний өдрүүдэд ЭМЯ, БШУЯ, ХНХЯ, ХНХЯ-ны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн холбоо "Эрхэм нандин сувд" ТББ-ын төлөөллөөс бүрдсэн баг ХНХЯ-ны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, "Эрхэм асралт илч хүүхэд хөгжүүлэх" төв, 3 сарын 15-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хөгжүүлэх “Ээлтэй ертөнц” төвийн үйл ажиллагаатай тус тус танилцсан.<br><br>- БШУ-ны сайдын 2024 оны 03 сарын 12-ны өдрийн А/60 дугаар тушаалаар байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэхчиг үүрэг бүхий төвийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааны дүрмийн төсөл”-ийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 8.7 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах уулзалтыг хийлээ. Үүнд: Нийслэлийн харъяа 3 хүүхдийн сэргээн засах төвийн удирдлагуудтай 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр уулзаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх урт хугацааны сэргээн засах тусламж, үйлчилгээ болон санхүүжилтийн талаар санал солилцов. Мөн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөхөөр ажиллаж байгаа Мөнхжаргал, Энхтуяа нартай 2 удаа уулзаж санал солилцсон. Уулзалтын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих төвийн санхүүжилтийг 3 сайдын хамтарсан тушаалар зохицуулах бөгөөд Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг төрөөс даадаг тул Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ болох хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл заслыг жил бүр улсын төсөвөөс хөтөлбөрт суурилсан санхүүжилтээр санхүүжүүлэх боломжийг судлах, аль нэг харъяалагдах ӨЭМТ, СЭМТ, Тосгоны ЭМТ-тэй гэрээлэн маягаар санхүүжүүлэх хувилбарыг ярилцаад байна. Мөн БШУЯ-аас 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах боловсрол: сургамж, анхаарах асуудал Семинарт оролцож, “Эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлж буй тусламж, үйлчилгээ” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн газарт Эрүүл мэндийн салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, албан хаагчдын талаарх 2023 оны дэлгэрэнгүй тоон мэдээллийг бүх ЭМБ-аас авч нэгтгэн, 2 хуудас дэлгэрэнгүй мэдээллийг 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 5/932 | | |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | тоот албан бичгээр хүргүүлсэн. Товч мэдээллээр, хөгжлийн бэрхшээлтэй нийт ажилтан, албан хаагчид 1016 байна. Үүнээс төрийн байгууллагад 956, хувийн салбарт 60 ажилтан ажиллаж байгаагаас эрэгтэй- 243, эмэгтэй-773, насны хувьд, 18-61 нас байна. Хөгжлийн бэрхшээлийн гарал үүслээр төрөлхийн 185, олдмол 831 ажилтан ажиллаж байна.<br>- ХНХЯ-д "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал Бодлого, үйл ажиллагаа-2023" номонд орох мэдээлэл (6 хуудас)-ийг бэлтгэн, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 5/2104 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2024 оны 02 дугаар сараас 5 сар хүртэлх хугацаанд Орбис ОУБ-ын шинэчлэх санамж бичиг, гэрээг хянаж, танилцуулга бичиж, батлуулсан. 2024 оны 3 сарын 21-нд Орбис ОУ-ын уулзалтад оролцсон, 05 сарын 20-ны өдрийн уулзалтын мэдээллийг бэлтгэсэн. | | |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.3.<br>БНЭУ-ын Засгийн газраас тус улсын "Jaipur Foot" хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй буцалтгүй тусламж үзүүлэхэд хамтран ажиллах | Үйл ажиллагааны тайлан | - | Арга хэмжээг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн салбарын оролцоог хангах | Газрын даргын өгсөн үүргийн дагуу:<br>- Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайдын яамнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2024 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, Гэмтэл, согог судлалын үндэсний төв болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайдын яам, Энэтхэг-Монголын Эрүүл мэндийн хамтын ажиллагааны төвийн төлөөлөл нартай уулзалтыг хийсэн.<br>- 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 1б/880 тоот албан бичгээр Энэтхэгийн ЭСЯ-аас ирүүлсэн 30/2024 албан тоотын хариуг хүргүүлж, хувийг ХНХЯ-д явуулсан.<br>- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/52 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байна.<br>- Энэтхэгээс ирэх 12 мэргэжилтний лицензийн асуудлыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 5/1202 тоот албан бичгээр ЭМХТ-д хүргүүлж шийдвэрлэсэн. Мөн ирсэн хойно хамтран ажиллах англи хэлтэй 5 ажилтанг олж хамтран ажиллаж байна. Гадаад мэргэжилтэнг урьдчилан | 02-06 сар | 100 |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | сэргийлэх үзлэгт орох асуудлыг зохицуулахаар ажиллаж байна.<br>- Орж ирэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн импортын нэг удаагийн зөвшөөрөл олгох асуудал талаар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/255 тоот албан бичгийг ЭЭХХЗГ болон ЭМЯ-д ирүүлж холбогдох албан тушаалтантай хамтран ажиллаж байна. Мөн холбогдох тушаал шийдвэрээр хангаж байна. Ажлын хэсгийн 2 удаагийн хуралд биечлэн, 3 удаагийн хуралд онлайнаар оролцож, viber-аар өдөр бүр мэдээлэл солилцож ажиллаж байна.<br>2024 оны 9 сарын 18-нд үйл ажиллагааг зохион байгуулсан. | | |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ)1. 4 "Монголын эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл"-ийн үйл ажиллагаа зохицуулах | Авсан арга хэмжээний тайлан | - | | Тус төслийн багийнхантай 2024 оны 5 сараас хойш 7-14 хоногт нэг удаа уулзаж, үйл ажиллагааг чиглүүлж ажилласан: Үүнд:<br>- Сувилахуйн чиглэлээр сувилагчийн цогц чадамжид суурилсан "Сувилагч мэргэжилтний хөгжил, чадварын түвшин, түүнийг тодорхойлох жишиг аргачлал, үнэлгээний жишиг загвар"-ын төслийг 2024 оны 6 сард хянаж, эцэслэн Эрүүл мэндийн байгууллагуудад туршин, үр дүн, тайланг тайлагнах талаар Эрүүл мэндийн хөгжлийн төвд чиглэлийн хамт 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 2/2942 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- 7 сарын 24- нд ЖАЙКА ОУ-ын байгууллагын төслийн хагас жилийн тайланг хянаж, төслийн багт хүргүүлсэн.<br>- Шинэ сувилагч, эх баригчийн сургалтын хөтөлбөрийн төсөлд ЭМЯ, холбогдох мэргэжлийн салбар зөвлөлөөс авсан санал, цаашид хэрэгжүүлэх чиглэлийн хамт ЭМХТ-д хүргүүлж, төвийн захирлаар хөтөлбөрийг баталсан. Шинэ сувилагчийн сургалтыг загвар байгууллага болох Орхон аймгийн БОЭТ дээр 2025 оны 8 дугаар сарын 12-нд, УХТЭ дээр 9 дүгээр сарын 5-ны өдөр тус тус эхлүүлээд байна. 2024 оны 12 сарын 05-ны өдөр Шинэ сувилагчийн эх баригчийн хөтөлбөрийн нээлтийг хийсэн. | 05-12 сар | 100 |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | - Тус төсөл дуусахтай холбоотой тул төслийн төгсгөлийн үнэлгээг хийхээр ирсэн ЖАЙКА ОУБ-ын төв оффисын үнэлгээний багтай 2024 оны 09 сарын 16-наас 10 дугаар сарын 04-ний өдөр хүртэл хамтран ажилласан.<br>- ЖАЙКА ОУБ-ын Хүний нөөцийн хөгжлийн газрын орлогч дарга Ёшида Томоятой ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын дарга уулзаж, төслийн үнэлгээний урьдчилсан дүнг сонссон.<br>- Ерөнхий мэргэшил судлал сургалт эрхлэх байгууллагын уулзалтыг 9 сарын 24-нд хийж, Сургалт эрхлэгч байгууллага хоорондоо туршлага солилцсон.<br>- 9 сарын 27-нд ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн бодлогын газрын даргаар ахлуулсан тус төслийн техникийн ажлын хэсгийн хурлыг хуралдуулсан.<br>- энэ оны 11 сарын 08-нд болсон Хамтарсан зохицуулах зөвлөлийн хурал, "Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл" -ийн үр дүнгийн тайлангийн хурлын бэлтгэл ажлыг хангасан. ын бэлтгэл ажил, хурлын хөтөлбөр, оролцогчдын мэдээлэл, ТНБД-ын нээлтийн үг, мэндчилгээний үгийг боловсруулсан.<br>- Ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх 11 байгууллагбн холбогдох албан тушаалтантай уулзалт хийж, санал солилцсон.<br>- Тус төслийн эцсийн тайланг хянаж байна. | | |
| 5 | Үүрэг даалгавар 1.5.<br>Томуу, томуу төст өвчний халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, | Авсан арга хэмжээний тайлан | - | | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр баталсан удирдамжийн дагуу:<br>- Эрүүл мэндийн яамны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд томуу, томуу төст өвчний халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээг УГТЭ-1, ЭХЭМҮТ-3, ХТС, АӨСҮТ, ЭНЭҮТ-д хяналтаар ажиллаж, удирдлагуудад анхаарах асуудлал, зөвлөмжийг өгсөн. ХШҮ-ний тайланг 3 удаа бичиж, танилцуулсан. | 11-12 сар | 100 |

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | үнэлгээ хийх, хүний нөөцийн талаар арга хэмжээ авах | | | | Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Томуу, томуу төст өвчний идэвхжлийн үед хүний нөөцийн талаар авах зарим арга хэмжээний тухай" А/456 дугаар тушаалыг батлуулсан.<br>- Тус тушаалыг ЭМХТ, НЭМГ, ЭХЭМҮТ-д 2/5025 тоот албан бичгийг хүргүүлсэн. Мөн 12 сарын 03-ны өдөр зүүм хурал зохион байгуулж, чиглэл өгч ажилласан.<br>- АШУҮИС-д Томуу, томуу төст өвчний идэвхжлийн үед хамтран ажиллах тухай 2/4958 тоот албан бичгийг хүргүүлсэн. | | |
| 6 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.6. Хүний нөөцийн хөгжлийн бодлого зохицуулалт | Үйл ажиллагааны тайлан | - | Арга хэмжээг хэрэгжүүлэхэд Эрүүл мэндийн салбарын оролцоог хангах | Стратеги төлөвлөлтийн газрын даргын өгсөн үүргийн дагуу:<br>- Эмч нарын VII их хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлыг 9 сарын 19-ний өдрөөс эхлэн хийсэн. Ерөнхий сайдын илгээлтийн төслийг боловсруулсан. Мөн тараах материалыг судлан, худалдах, худалдан авах 3 төрлийн гэрээг байгуулж, бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Оройн хүлээн авалтын хөтөлбөрийг боловсруулж, батлуулан, 10 дугаар сарын 18-ны арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээний тайланг хугацаанд нь өгч ажилласан.<br>- 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 4/4723 тоот албан бичгээр Ажлын хэсэгт ажиллах ажилтны нэр, мэдээллийг холбогдох байгууллагаас авч, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/446 дугаар тушаалаар "Нийгмийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх асуудлаар холбогдох эрх зүйн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж"-ийг батлуулсан.<br>- Ажлын хэсгийн хурлын хөтөлбөрийг батлуулж, 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан.<br>- Тус ажлын хэсгээс өгсөн үүргийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх асуудлаар холбогдох эрх зүйн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөний төслийг НЭМҮТ, Сувилахуйн сургуультай хамтран боловсруулж, ажлын хэсэгт танилцуулсан.<br>- ГБХНХЯ-д Хамтран ажиллах тухай 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 4/5012 тоот албан бичгийг хүргүүлсэн. | 02-06 сар | 100 |

161

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | - БЯ-д Боловсролын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төсөлд 1а/4939 тоот албан бичгээр санал хүргүүлсэн<br>- СХЗГ-т Ажил мэргэжилд тавих ерөнхий шаардлага" стандартын төсөлд 2024-12-02 4/5011 албан бичгээр санал хүргүүлсэн.<br>- ГБХНХЯ-д Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, төслийн үзэл баримтлал, танилцуулгад 2024-11-13-ны өдрийн 1а/4725 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Монголын Эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбооноос ЗГ, ЗГХЭГ-т ирүүлсэн дэмжлэг, шаардлагад өгөх хариуг судлан боловсруулж танилцуулан асуудлыг шийдсэн. Мөн Эрүүл мэндийн ажилтны хувцас, хэрэглэлийн хангалт, ашиглагдах хугацааны талаар мэдээлэл авах 10 асуултыг боловсруулан гүүгл шийтээр санал авахаар ажиллаж байна. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Эрүүл мэндийн чиглэлээр болон өөрийн албан тушаалтай хамааралтай холбогдох | Гэрчилгээ | 2 | 1 | 2024 оны 4 сарын 17-18-ны өдөр Филиппин улсын Манилад болох "Ахмад настны зайлсхийж болох сохролоос сэргийлэх" сургалтад оролцох урилга авч, удирдлагуудад танилцуулсан ч ажлын улмаас оролцож чадаагүй. | 01-12 сар | 100 |

164

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | чиглэлийн сургалтад хамрагдах | | | | 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр "Холголт цооролтын үед урьдчилан сэргийлэх, суюилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлж, зөвлөгөө өгөх" сургалтад сууж батламж авсан.<br>2024 оны 10 сарын 23-нд Монгол-Японы эмнэлэг, ЖАЙКА ОУБ-тай хамтран зохион байгуулсан Олон улсын сувилагчдын анхдугаар эрдэм, шинжилгээний хурал, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн 95 жилийн ойд зориулсан 11 дүгээр сард зохион байгуулсан Олон улсын эрдэм шинжилгээний хуралд тус тус оролцож, гэрчилгээ авсан. | | |
| 2. | Арга хэмжээ 2. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй сургалтад хамрагдах | Суралцсан цаг | - | 2 | "Төрийн албан хаагчийн тасралтгүй хөгжих, гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж үр дүн",<br>"Үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл",<br>"Нийгмийн даатгалаас сангаас олгох тэтгэмжийн төрөл, тэтгэмж авах эрх, хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх"<br>"Төрийн албан хаагдын сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйл",<br>"Төрийн албаны үйл ажиллагааны стандартад тавих ерөнхий шаардлага",<br>"Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд"<br>"Төрийн албан хаагчийн ёс зүй (Дижитал ёс зүй)"<br>""Төрийн албан хаагчийн ёс зүй: Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа",<br>"Төрийн албан хаагчийн цалин хөлс/орон нутгийн нэмэгдэл" | 01-12 сар | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
Сувилахуйн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн ....................../.................../ 2024 оны 12 дугаар сарын

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*